

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 2 дугаар
сарын 19-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

“Эрдэнэт хивс” ХК-ийн талаар авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Хорооны 2008 оны 267 дугаар тогтоолоор “Эрдэнэт хивс” ХК-ийн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэснээс хойш 4467 хувьцаа эзэмшигчдээс ердөө 57 хувьцаа эзэмшигч нь ногдол хувиа авсан, зарим хувьцаа эзэмшигчид компанид хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх хүсэлтээ Хороонд болон компанийн удирдлагад ирүүлсэн, “Эрдэнэт хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдээс хувьцаагаа эргүүлэн худалдан авах үнийг үндэслэлгүй тогтоосон гэж үзэж уг үнийг дахин тогтоох талаар арга хэмжээ авч өгөхийг хүссэн өргөдөл гомдлыг удаа дараа Хороонд ирүүлсэн, мөн “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас дээр дурдсан үнэлгээг дахин судлан үзэхийг хүссэн болно. Хэдийгээр тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл хувьцааг эргүүлэн авах үнийг тогтоодог боловч дээрх нөхцөл байдлын улмаас хувьцаа эзэмшигчдээс гаргасан өргөдлүүдийг шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчид компанийн талаар мэдээлэл авах боломжыг олгож уг хуралд хувьцаа эзэмшигчдийг оролцох боломжоор хангасны үндсэн дээр компанийг өөрчлөн байгуулагдах асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар дахин хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, мөн компанийн хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх нь зүйтэй гэж үзэж Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2-т заасныг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт хивс” ХК-ийг өөрчлөн байгуулж хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар дахин хэлэлцүүлэх, уг хуралд жижиг хувьцаа эзэмшигчдийг оролцуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах, компанийн хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэхийг “Эрдэнэт хивс” ХК /ГУЗ-ийн дарга Ш.Энхбаяр, гүйцэтгэх захирал Ө.Мянганбаяр/-д үүрэг болгосугай.

2. Энэ тогтоол хүчин төгөлдөр болохоос өмнө Хорооны 2008 оны 267 дугаар тогтоолд заасны дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аас ногдол хувиа авсан 57 хувьцаа эзэмшигчдэд энэ тогтоолын талаар мэдэгдэх, улмаар “Эрдэнэт хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх эсэх шийдвэрээ гаргах шаардлагатай тухай мэдэгдэх, ийнхүү хэвээр үлдэхээр шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн Хороонд болон “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д хандах ажлыг 2009 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор өөр өөрийн харилцагчдын хүрээнд зохион байгуулахыг бүх брокер, дилерийн компаниудад үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 2-т заасны дагуу “Эрдэнэт хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх эсэх талаар шийдвэрээ ирүүлж, улмаар Хорооноос энэхүү асуудлаар шийдвэр гаргах хүртэл 57 хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байсан хувьцааг тус тусын дансанд нь байршуулж, тусгаарлахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

4. Хорооны 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг энэ тогтоолын 1, 2, 3-т заасан үүргийг биелүүлж дуусах хүртэл хугацаагаар түр зогсоосугай.

5. Энэ тогтоолын 2-т заасан ажлыг хэрхэн зохион байгуулсан талаар болон хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн баримт бичгүүдийг үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа Хорооны 2009 оны 3 дугаар сарын хуралдаанд танилцуулахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

6. Хувьцаат компани өөрчлөн байгуулагдаж хязгаарлагдмал хариуцлагатай компани болох үед хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох талаар зохицуулсан Компанийн тухай хууль болон бусад журмын зохицуулалтыг судлан үзэж жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Хорооны эрх хэмжээг нэмэгдүүлэх болон холбогдох бусад өөрчлөлтийг оруулах талаарх саналаа боловсруулан 2009 оны 4 дүгээр сард багтаан Хороонд танилцуулахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ